



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2024. 08. 08 № 271
танай _____-ны № _____-т

Баруун-Урт Сумын
СОНГУУЛИЙН ХОРОО-Д

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, ТЭЗ-ийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Ардчилсан намын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Мөрийн хөтөлбөр (..... хуудас)-ийг хавсаргав.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

Баруун-Урт сумын Ардчилсан намын хорооны
2024 оны ... дугаар сарын-ны өдрийн
....дүгээр албан бичгийндугаар хавсралт

**БАРУУН-УРТ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН
2024-2028 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Баруун-Урт сумын Ардчилсан нам "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, хөгжлийн хөтөлбөр, "Сүхбаатар аймгийн хөгжлийн хэтийн зорилт 2020-2028", Сүхбаатар аймгийн Ардчилсан намын 2024-2028 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр, Намын дүрэм, үнэт зүйлс, үзэл баримтлал, Таван тулгуур бодлого болон олон нийтийн санаа бодолд үндэслэн иргэд сонгогчдынхоо итгэл дэмжлэгээр бодлогоо хэрэгжүүлж хүрсэн амжилтандаа тулгуурлан, 2024-2028 оны сумын ИТХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрөө хүргэж байна.

1. ЭРҮҮЛ МЭНД

- 1.1. Архи тамхины хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, буруу хооллолт, эмийн зохистой хэрэглээ, амьдралын буруу хэв маяг, дадал зуршлыг бууруулахад чиглэсэн "ЗӨВ ХЭВШИЛ - ЗӨВ АМЬДРАЛ" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.2. Уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан эмийн бус аргаар бага насны хүүхдийг чийрэгжүүлэн, суурь болон цочмог өвчлөл, эрдэс амин дэмийн дутагдлыг бууруулах зорилгоор "НАРХАН" сувиллын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан өргөжүүлнэ.
- 1.3. Төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй хамтран ажиллаж "ЭРҮҮЛ ШҮД ХӨТӨЛБӨР"- ийг хэрэгжүүлэх замаар 0-16 насны хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн өвчлөлийн тархалтыг бууруулна.
- 1.4. Шүдний эмчийг үе шаттай бэлтгэн өрхийн эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургуулийг шүдний кабинеттэй болгоно.
- 1.5. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн чадавхи, нийгмийн хамгааллыг бэхжүүлж, өрхийн эрүүл мэндийн төвийг стандартад нийцсэн барилга, тоног төхөрөөмжөөр хангаж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.
- 1.6. Мэдээллийн технологид суурилсан оношилгооны хэлбэрүүдийг нэвтрүүлж, Эрүүл мэндийн салбарт цахим шилжилтийг эрчимжүүлнэ.
- 1.7. Хувь хүн, гэр бүл, байгууллага хамт олны идэвхи оролцоонд тулгуурлан амьдралын зөв дадлыг нэмэгдүүлэх замаар зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалтаас сэргийлж нас баралтын хувийг бууруулна.

- 1.8. Бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж, эрүүл аж төрөх дадлыг эзэмшүүлэн, иргэн бүрийг 2 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд тогтмол хамрагддаг болгож хэвшүүлнэ.
- 1.9. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдлийг тогтвортой бууруулна.
- 1.10. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжиж, тэдэнд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүүг багасгана.
- 1.11. Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэдэд эрүүл амьдралын дадлыг хэвшүүлэн, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх замаар хүн амын дундаж наслалтыг 80+ хүргэнэ.
- 1.12. Орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаад улсад суралцах, туршлага судлахад дэмжлэг үзүүлж, шаардлагатай нэр төрлөөр мэргэшсэн эмч нарыг орон нутагт зөвлөхөөр ажиллуулна.

2. БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААН

- 2.1. “Хөгжсөн хүүхэд- Хөгжлийн суурь” хөтөлбөр хэрэгжүүлж, боловсролын чанар, хүртээмжийг сайжруулна.
- 2.2. “ДЭЛХИЙД ӨРСӨЛДӨХ БАРУУН-УРТЧУУД” дэд хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 2.3. Албан байгууллага, аж ахуй нэгж бүр монгол бичгийн хэрэглээний орчинг бүрдүүлж, үндэсний бичиг, соёлоо эрхэмлэгч сум болно.
- 2.4. Ерөнхий боловсролын сургуульд шаардлагатай мэргэжлээр зөвлөх, зочин, ментор багш ажиллуулж, “БАГШ СОЛИЛЦОО” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.5. Орон нутагт хувийн хэвшлийн сургууль, цэцэрлэг байгуулах санал, санаачилгыг дэмжинэ.
- 2.6. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн боловсролын сургалтын төвд “Эмч”, “Сэтгэл зүйч” ажиллуулах асуудлыг үе шаттай шийдвэрлэнэ.
- 2.7. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын эрүүл мэндийг дэмжих төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.8. Нийгмийн хариуцлагын хүрээнд “Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөр хэрэгжүүлэх санал санаачилгыг дэмжинэ.
- 2.9. Мэдээллийн технологид суурилсан “Цахим сургалт” зохион байгуулах үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 2.10. Насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, иргэн бүрийн насан туршдаа суралцахуйн хэрэгцээ шаардлага нийцсэн сургалтыг чанартай зохион байгуулна.
- 2.11. Цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

- 2.12. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ээлтэй орчин, нөхцөлийг сайжруулан, боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй, эрсдэлт бүлгийн суралцагч нэг бүрд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, боловсролд тэгш хамруулна.
- 2.13. Цэцэрлэг, сургуулийг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгож, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.
- 2.14. Хүүхэд бүрийг сургууль, цэцэрлэгт хамрагдах боломжийг нэмэгдүүлж, чанартай боловсрол олгоно.
- 2.15. Сургууль, цэцэрлэгийг орчин үеийн шаардлагад нийцсэн сургалтын хэрэглэгдэхүүн, техник, тоног төхөөрөмжөөр хангаж, боловсролын чанарт ахиц гаргана.
- 2.16. Орон нутагт инноваци, шинэлэг санаа нэвтрүүлэх санал санаачилгыг дэмжинэ.
- 2.17. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжилд дэмжлэг үзүүлж, үнэлэмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.
- 2.18. Бүх шатны сургалтын байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, цэцэрлэг, сургуулийн анги, бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд хүргэнэ.

3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

- 3.1. Өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх замаар амьжиргааны түвшинг дээшлүүлж, өрхийн орлогыг тогтмол нэмэгдүүлнэ.
- 3.2. Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гэрээ, хэлэлцээрийг бүх шатанд байгуулж, үр дүнг нэмэгдүүлнэ.
- 3.3. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлог, хэрэгцээнд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 3.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан нийгмийн амьдралд бусадтай адил тэгш оролцох боломжийг олгоход дэмжлэг үзүүлэх "ХУВИЙН ТУСЛАХ" үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 3.5. Шинэ технологи, шинэлэг технологийг орон нутагтаа нутагшуулах зорилгоор гарааны бизнес, бизнесийн орчин нөхцлийн талаарх ойлголт, мэдлэг мэдээллээр хангах сургалт нөлөөллийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 3.6. Шинэ технологи, инноваци шингээсэн гарааны бизнес /СТАРТ АП/ эрхэлж буй 18-45 насны иргэдийг дэмжиж, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- 3.7. Байгалийн давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөлөл, малчдын эрэлт, хэрэгцээ, шаардлагатай уялдуулан "Малжуулах" төслийг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 3.8. Ажил хөдөлмөр эрхэлдэг эцэг эхэд ажил, ар гэрийн амьдралын тэнцвэрийг хангах зорилгоор ажлын цагийн зохицуулалтыг оновчтой

- зохион байгуулсан аж ахуй нэгж, албан байгууллагыг дэмжиж, хамтран ажиллана.
- 3.9. Төрийн байгууллага, нийтийн үйлчилгээний газар, нийтийн эзэмшлийн зам талбайд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулна.
- 3.10. Төр-хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, төрийн бус байгууллагуудын 144 чадавхийг дээшлүүлж, хамтран ажиллана.
- 3.11. Сэтгэл зүйн эрүүл мэндэд чиглэсэн жишиг үйлчилгээг үзүүлэн, сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж “Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх төв”-ийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- 3.12. Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Олон Улсын байгууллагуудтай хамтран ажиллаж төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг татна.

4. СПОРТ, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР

- 4.1. Өсвөр үе, залуучуудыг спортын олон төрлөөр хичээллэж бие бялдраа хөгжүүлэх, спортын амжилт гаргах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 4.2. Стандартын шаардлага хангасан чийрэгжүүлэлт, биеийн тамирын задгай талбай, байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 4.3. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх орчин, нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
- 4.4. Иргэдийг нийтийн биеийн тамираар хичээллүүлэх, эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах зорилгоор бие бялдрын түвшин тогтоох сорилын төвийг байгуулна.
- 4.5. Улс, Олон улсын, тив, дэлхийн аваргын тэмцээнд орон нутгаа төлөөлөн оролцох багш, дасгалжуулагч, баг, тамирчдыг урамшуулна.

5. СОЁЛ УРЛАГ

- 5.1. Хүүхдийг эрхэмлэн дээдэлж, тэдний амрах, хөгжих, чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлэх ээлтэй, аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор “ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ОРДОН”-г байгуулна.
- 5.2. Соёл урлаг, өв соёлыг хөгжүүлэх, сурталчлан таниулах, хамгаалахад чиглэсэн соёл урлагийн хөгжлийн хөтөлбөр, төслийг хэрэгжүүлнэ.
- 5.3. Монгол хүн үндэсний өв соёлоороо бахархах өвлүүлэх, үндэсний бичиг соёлоо түгээн дэлгэрүүлэх, монгол бичгийн судалгаа, сурталчилгааг өргөжүүлэх зорилгоор “Жаахан шаргын нутаг” монгол бичгийн уралдааныг бүсийн хэмжээнд үргэлжлүүлэн зохион байгуулна.
- 5.4. Угийн бичиг, удмын түүхээ хөтлөхөд программ хангамжийг нэвтрүүлж, хөтлөлтийг 50+ хувьд хүргэнэ.

- 5.5. Бүтээлч үйлдвэрлэлийг дэмжин, соёл урлагийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлнэ.
- 5.6. Нүүдлийн ахуйд суралцах өв соёлын түгээн дэлгэрүүлэх “Нүүдэлчин монголчууд” арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 5.7. Угсаатны онцлогийг илэрхийлсэн гар урлалын брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, зах зээлд нэвтрүүлэхэд орон нутгаас дэмжлэг үзүүлнэ.

6. ХҮҮХЭД, ГЭР БҮЛ, ЗАЛУУЧУУД

- 6.1. Гэр бүлийн гишүүн бүрт гэр бүлийн боловсрол олгох Монгол гэр бүл боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 6.2. Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих “ГЭРТЭЭ ГЭРЭЛ АСААЯ” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 6.3. Хохирогчийг хамгаалах “Түр хамгаалах байр”-ны үйлчилгээг өргөжүүлж, хүчирхийлэлд өртсөн үйлчлүүлэгчийг хамгаалах, нөхөн сэргээх болон хөгжлийн зэрэг хариу үйлчилгээг нэмэгдүүлнэ.
- 6.4. Стандартын шаардлага хангасан Өсвөр үе, залуучуудын хөгжлийн төвийг үйл ажиллагааг сайжруулж, залуучуудын хөгжил оролцоог дэмжинэ. Залуучуудад чиглэсэн зарим үйлчилгээг ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлэн залуучуудын үйлчилгээнд хамрагдалтыг 50 хувиар нэмэгдүүлнэ.
- 6.5. Өсвөр насны хүүхдүүдэд “Технологийн боловсрол олгох, ур чадвар олгох” төслийг хэрэгжүүлнэ.
- 6.6. Гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр дагнан ажиллах хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан суманд ажиллуулж, мэргэшүүлнэ.
- 6.7. “БАНУУН-УРТЫН ЗАЛУУЧУУД ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР”-ийг хэрэгжүүлж орон нутгийн залуучуудын хөгжлийг дэмжиж, нийгмийн амьдралд оролцох оролцоог нэмэгдүүлэх замаар эрүүл бие бялдартай, орон нутагтаа ажиллаж хөдөлмөрлөх, бүтээлч хариуцлагатай, амьдрах ухааны чадвартай залуу үеийг төлөвшүүлнэ.
- 6.8. Шинэ төгсөгчдийг хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх зорилгоор “ЗАЛУУЧУУДЫН ЗУНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХӨТӨЛБӨР”-ийг хэрэгжүүлнэ.

7. ЭДИЙН ЗАСАГ

- 7.1. Төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгож сахилга хариуцлагыг сайжруулах замаар үр ашгийг нэмэгдүүлнэ.
- 7.2. Төсөв, санхүүгийн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгон төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг ил тод, хэмнэлттэй зарцуулах нөхцөлийг бүрдүүлнэ.

- 7.3. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлнэ.
- 7.4. Статистик мэдээллийн хамрах хүрээ, тооллого, судалгааны үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
- 7.5. Орон нутгийн төсвийн төлөвлөлт, зарцуулалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлж, хяналтыг сайжруулна.

8. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ

- 8.1. Хөдөө аж ахуйн цогцолборыг өргөжүүлж малын тэжээлийн ургамал, төмс хүнсний ногоо тариалалтыг нэмэгдүүлэн, цөм сүрэг үржлийн төв байгуулан, сумын өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг нэмэгдүүлнэ.
- 8.2. Тариалангийн зориулалттай газрын ашиглалтыг сайжруулан, талбайн хэмжээг нэмэгдүүлж шинээр 10 хүртэл га атар газрыг тариалангийн газарт шилжүүлэх, эргэлтийн талбайг 50 га-д хүргэх, усалгаатай тариалангийн талбайг 10 га-аар нэмэгдүүлнэ.
- 8.3. Зуны нийлэг хальсан хүлэмжийн аж ахуйн үйлдвэрлэлийг 5 га хүртэл нэмэгдүүлэн, хүн амыг жилийн туршид шинэ ургацын ногоогоор тогтвортой хангахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, дулааны хангамж, дэд бүтэц бүхий газарт 0,5 га өвлийн хүлэмжийн аж ахуйг дэмжинэ.
- 8.4. Иргэн аж ахуй нэгжийн хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачлагыг дэмжинэ.
- 8.5. Өрхийн төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлж, дотоодын хэрэгцээний 50-аас доошгүй хувийг хангана.
- 8.6. Газар тариалангийн зориулалт бүхий техник, технологийн шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлж, санхүүгийн түрээсийн үйлчилгээг хөгжүүлнэ.
- 8.7. Хөрс, цаг уурын онцлогт тохирсон баталгаат сортын үрийн хангамж, тэжээлийн тариалалт, үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- 8.8. Хүнсний үйлдвэр, нийтийн хоолны чанар аюулгүй байдалд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт тавьж, иргэдийн эрүүл, чанартай хүнсээр хангана.
- 8.9. Бэлчээрийн мэрэгч амьтан үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг зохион байгуулж, усжуулах, хамгаалах, нөхөн сэргээх замаар нөөц бэлчээрийг нэмэгдүүлнэ.
- 8.10. Бэлчээрт ашиглаж байгаа, инженерийн хийцтэй болон энгийн уурхайн худаг шинээр гаргаж ашиглахгүй байгаа худгуудыг шат дараатай сэргээн засварлана.
- 8.11. Хадлангийн талбай бүхий сумдуудтай гэрээ байгуулж, өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлнэ.

9. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ

- 9.1. Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олголтыг орон нутгийн үйлдвэрлэлийн бодлоготой уялдуулан олгож, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 9.2. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг дэмжин орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр хүн амын хүнсний хэрэгцээг хангана.
- 9.3. Мах, ноос ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэр байгуулах аж ахуй нэгжийн санаачилгыг хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр дэмжинэ.
- 9.4. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглах, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг олон улсын жишигт хүргэнэ.
- 9.5. Хот, суурин газрын хүнсний нийтийн хэрэглээний малыг зөвхөн үйлдвэрийн аргаар нядалж боловсруулах стандартыг бүрдүүлж, энэ чиглэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 9.6. Дэвшилтэт техник, өндөр технологи, инновацад суурилсан дахин боловсруулах үйлдвэр, орон нутгийн эко жижиг, дунд үйлдвэрийг санхүүгийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- 9.7. Оюуны өмчийн патент, чанар стандартын баталгаатай орон нутгийн бренд бүтээгдэхүүн, үйлчилгээний тоог нэмэгдүүлнэ.

10. МАЛ АЖ АХУЙ

- 10.1. Бог малын хээлтүүлэгчийг Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж болон мэргэжилтний хяналтад төвлөрүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулж өсвөр хээлтүүлэгч худалдан авч малын чанарыг сайжруулна.
- 10.2. “Хариуцлагатай, чинээлэг малчин” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 10.3. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж байгуулах, хээлтүүлэгч болон цөм сүргийн малыг мэргэжлийн байгууллагын хяналтад авах, малын генетик нөөцийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулан нэгж малаас авах ашиг шимийг дээшлүүлнэ.
- 10.4. Өндөр ашиг шимт мах, сүүний чиглэлийн үүлдрийн үхэр, мах ноосны чиглэлийн хонь, махны чиглэлийн гахай, өндөгний чиглэлийн шувууны эрчимжсэн аж ахуйг хөгжүүлж, ашиг шимийг нь нэмэгдүүлнэ.
- 10.5. Эрчимжсэн аж ахуй эрхлэгчийг бодлогоор дэмжиж төв суурин газрын иргэдийн сүү, мах, өндөгний хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр төрөлжсөн фермерийн үйл ажиллагааг дэмжинэ.
- 10.6. Малын гоц халдварт, халдварт, зооноос, халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлж, малын өвчнөөр тайван бүсийг тогтооно.
- 10.7. Халдварт зооноос өвчний гаралтыг багасган уг өвчнөөр тайван, халдваргүй бүсээр баталгаажуулна.

11. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ

- 11.1. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хөдөөгийн бүлэг, малчид болон сумын ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн гал түймэртэй тэмцэх багаж хэрэгслийг сайжруулна.
- 11.2. Баруун-Урт сумын төв суурин газрын ногоон байгууламжийн ургалтыг хувийг нэмэгдүүлж, Тэрбум мод хөдөлгөөний хүрээнд 280,0 мянган ширхэг модыг шинээр тарина.
- 11.3. Аймгийн төвийн нийтийн эзэмшлийн талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, хашаа хамгаалалтыг сайжруулна.
- 11.4. Усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалж, булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах, урсацыг нэмэгдүүлэх ажлыг хийж гүйцэтгэнэ.
- 11.5. Баруун-Урт сумын айл өрхийн эко шийдлээр хийгдсэн нүхэн жорлонгийн тоог нэмэгдүүлнэ.
- 11.6. Хогийн нэгдсэн цэгийн камержуулах ажлыг хийж, хог хаягдал тархахаас сэргийлсэн хашаажуулалтын асуудлыг шийдвэрлэнэ.
- 11.7. Шинэ цэвэрлэх байгууламжийн хаягдал саарал усыг ашиглан цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, мод үржүүлгийн газар байгуулах ажлыг дэмжин ажиллана.
- 11.8. Нийтийн эзэмшлийн зам талбай, орон сууцны хогийн савыг шинэчлэн сайжруулж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгана.

12. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

- 12.1. Орон нутгийн аялал жуулчлал буюу Уртын голын цэцэрлэгт хүрээлэнг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 12.2. Аялал жуулчлалын гол чиглэлийн зам дагуу түр буудаллах болон боловсон ариун цэврийн байгууламж, хогийн цэгүүдийг хүртээмжтэй байршуулна.
- 12.3. Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- 12.4. Харьяалах нутаг дэвсгэртээ аяллын маршрутын дагуу тэмдэг тэмдэглэгээ, нэгдсэн хаягжуулалт бий болгоно.
- 12.5. Аялал жуулчлалын хөтөч-тайлбарлагч, үйлчилгээний байгууллагын ажилтнуудын ур чадварыг сайжруулах, иргэдийн аялал жуулчлалын талаарх мэдлэг, боловсролыг нэмэгдүүлж, зөв зохистой аялах дадал, соёлыг нэвтрүүлэх нөлөөллийн ажлыг зохион байгуулна.
- 12.6. Орон нутгийн иргэдийн өв соёлын үнэт зүйлс, гар урлал, уламжлалт соёлыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх санаачлагыг дэмжинэ.
- 12.7. Зам дагуух үйлчилгээний байгууллагын мэдээллийг Гүүгл газрын зургийн байршилд байршуулж, жуулчдыг мэдээллээр хангана.

13. ТЭЭВЭР, ЛОГИСТИК

- 13.1. Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км хатуу хучилттай хүнд даацын авто зам барих ажлыг дэмжин, хамтран ажиллана.
- 13.2. Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн 433 км төмөр замын төслийг эхлүүлэхэд санал санаачилга гарган хамтран ажиллана.
- 13.3. Авто зам, замын байгууламжийн хамгаалалтын зурваст орсон айл өрх, аж ахуй нэгж байгууллагатай хамтран ажиллах, шилжүүлэх, газар ашиглалт, зохион байгуулалтын менежментийг хийж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний гудамж, замын сүлжээний ажлыг хамтран хийж гүйцэтгэнэ.
- 13.4. Хотын хэвтээ, босоо, тойрог чиглэлийн авто замын сүлжээг холбох авто замуудын ажлыг үргэлжлүүлэн бетонон хучилттай авто замыг алфальтан хучилттай болгон шинэчлэх ажлыг зохион байгуулна.
- 13.5. Хотын төвийн 4,5 дугаар тойрог зам дагуу дугуйн замыг байгуулах ажлыг дуусгана.
- 13.6. Нийтийн тээврийн чанар хүртээмжийг нэмэгдүүлж явах чиглэлийн тоог нэмэгдүүлнэ.

14. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТ

- 14.1. Гэр хорооллыг иргэдийн оролцоотойгоор дахин төлөвлөж, төвлөрсөн, хэсэгчилсэн, бие даасан инженерийн дэд бүтцэд холбогдсон иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.
- 14.2. Үерийн эрсдэлтэй бүсүүдэд шинээр далан суваг барих, хөрс болон замын ус зайлуулах шугам барихдаа ус хуримтлуулах хөв цөөрөм, далд усан сангууд барьж байгуулах усыг олон зориулалтаар ашиглах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 14.3. Төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан орон сууцны барилга, хотхон, хороолол барих ажлыг сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн үе шаттай хэрэгжүүлнэ.
- 14.4. Түрээсийн орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 14.5. Боловсрол хороолол, хотхонуудын дундах талбайн тохижилтын ажлыг төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлж, дуусгана.
- 14.6. Орчин үеийн шийдэлтэй боловсрол, соёл, спорт, сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.
- 14.7. Орон нутгийн барилгын материалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, хайрганы карьер, ханын дүүргэгч хөнгөн блок, барилгын бетон хийц, асфальт бетон, хавтгай шилний үйлдвэр барих санал санаачилгыг дэмжинэ.
- 14.8. Сумын хэмжээний хаягийн нэгдсэн системийг шинэчлэх, хашаа, гудамж, байшингийн хаягийг журам, стандартад нийцүүлнэ.
- 14.9. Иргэнд өмчлүүлэх боломжтой газрын нөөцийг тогтоон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулан батлуулж газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 14.10. Төрийн болон орон нутгийн өмчийн барилгуудыг паспортжуулах, гэрчилгээжүүлнэ.

- 14.11. Барилгын газар хөдлөлтөд тэсвэрлэлтийг тогтоож, чанарыг дээшлүүлнэ.
- 14.12. Сум, суурин газрын төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулна.
- 14.13. Хүн амыг эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан ундны усаар хангана.
- 14.14. Цэвэр усны хайгуул хийж, гүний худгийн тоог нэмэгдүүлнэ.
- 14.15. Нийтийн хуучин орон сууцнуудын дундын өмчлөлийн цэвэр, бохир усны шугам сүлжээг үе шаттайгаар шинэчлэх ажлыг зохион байгуулж, хамтран ажиллана.
- 14.16. Хуучин цэвэрлэх байгууламжийг лагийг боловсруулж үнэргүйжүүлнэб

15. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

- 15.1. Баруун-Урт хотоо амьдрахад таатай, байгаль орчинд ээлтэй, хот болгон хөгжүүлнэ.
- 15.1.1. Дэд төвийг байгуулна.
- 15.1.2. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батлуулна.
- 15.1.3. Хорооллын хэсэгчилсэн төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулж, ажлыг эхлүүлнэ.
- 15.1.4. Иргэдийн амрах, зугаалах газар, бичил цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэнгийн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 15.1.5. Уртын голын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын ажлыг дуусгана.
- 15.1.6. Хүүхдийн парк барьж байгуулна.
- 15.1.7. Морьтой хөшөөний ажлыг хувийн хэвшлийн байгууллагуудаар хийлгэж, хөшөөний бүтээн байгуулалтыг дуусгана.
- 15.1.8. Эко хороололд цэцэрлэгт хүрээлэн шинээр барьж, барилгачдын цэцэрлэгт хүрээлэнг сэргээн засварлана.
- 15.1.9. Баруун-Урт нисэх буудлыг нүүлгэн шилжүүлж, УБ-Баруун-Урт чиглэлийн нислэгийг сэргээх ажлын талаар санал хүсэлтээ холбогдох байгуулагад тавьж шийдвэрлүүлнэ.
- 15.1.10. Нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 15.1.11. Аймгийн төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлэн, орчин үеийн шийдэлтэй болгон зохион байгуулж, ашиглалтыг сайжруулна.
- 15.1.12. Мэдээлэл холбооны суурь дэд бүтцийг өргөтгөнө.
- 15.1.13. Жавхлант хаус хороолол, Эко, Боловсрол, Жавхлант хорооллууд руу холбоо хангамжийн сувагчлал татаж, утастай болон утасгүй интернэтийн сүлжээнд холбоно.

16. НЭЭЛТТЭЙ ЗАСАГЛАЛ

- 16.1. Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангаж, төрийн үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналтыг бий болгоно.

- 16.2. Төрийн байгууллага, нийгэм, эдийн засаг соёлын хүрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, бүх түвшинд жендэрийн бодлого хэрэгжүүлнэ.
- 16.3. Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн санхүүжилтийг жил бүр нэмэгдүүлж, хамрах хүрээг өргөжүүлнэ.
- 16.4. Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлт, албан бичиг солилцооны үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, сүлжээг бий болгоно.
- 16.5. Цахим үйлчилгээний нэгдсэн портал буюу e-mongolia системийн операторын хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдэд төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй хүргэнэ.
- 16.6. Мэдээллийн технологи, харилцаа, холбооны хамрах хүрээг тэлэн, өндөр хурдны интернэт сүлжээг хүртээмжтэй болгож, иргэд, аж ахуйн нэгжийн төрөөс авах үйлчилгээг бүрэн цахимжуулна.
- 16.7. Орон нутагт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр олон улсын төсөл, хөтөлбөр, гадаадын орнуудтай бүх талын хамтын ажиллагааг хөгжүүлнэ.
- 16.8. Төрийн албан хаагчдын сургалт хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, төрийн албан хаагчийн мэдлэг ур чадвар, ажлын гүйцэтгэлийг сайжруулна.

17. БАТЛАН ХАМГААЛАХ

- 17.1. Гамшгаас хамгаалах ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийг техник, тоног төхөөрөмжөөр үе шаттай хангана.
- 17.2. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд орон нутгийн төрийн болон мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангаж, гамшгийг даван туулах, дасан зохицох чадавхыг бэхжүүлнэ.
- 17.3. Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл, ёс зүй, ухамсрыг төлөвшүүлэх, эх орноо хайрлан хамгаалах үйл ажиллагааг сурталчлан таниулж, монгол хүн болж төрснөөрөө бахархах үзлийг төлөвшүүлнэ.

18. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

- 18.1. Хууль зүйн анхан шатны зөвлөгөө өгөх, зорилтот бүлэгт өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх хууль зүйн туслалцааны төвийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжиж, хамтран ажиллана.
- 18.2. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд үр дүнтэй зохион байгуулж, хүнд суртал, авлига үүсэхээс урьдчилан сэргийлж, ил тод, нээлттэй засаглалын бодлого хэрэгжүүлнэ.
- 18.3. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг тогтоох ажлыг мэргэжлийн байгууллагуудыг дэмжиж, хамтран ажиллах замаар иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг бий болгоно.

- 18.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж, үр дүнг тооцон, хууль дээдлэх хандлагыг төлөвшүүлнэ.
- 18.5. Олон нийтийн цагдаагийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулан, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.
- 18.6. Сумын нутаг дэвсгэрийг бүрэн камержуулан, камерын хяналтын нэгдсэн системд холбож, ард иргэдийн аюулгүй, таатай орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.
- 18.7. Бүх нийтийн эрх зүйн болон хүний эрхийн боловсролыг дээшлүүлэхэд шаардлагатай нөөцийг бүрдүүлж, эрх зүйн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг тогтмол, үр дүнтэй зохион байгуулна.
- 18.8. Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, албан тушаалтны ёс зүй, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэн, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын тогтолцоог бий болгож ажиллана.

СҮХБААТАР АЙМГИЙН БАРУУН-УРТ СУМЫН АРДЧИЛСАН НАМ